

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Л.Эрдэнэбулган
ХСИС-ийн Төгсөлтийн дараах сургуулийн
магистрант, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа нь дан ганц Монгол Улсын биш дэлхий нийтийн хэмжээнд чухал асуудал болоод байна.

Хууль зүйн салбарын шинэчлэлтийн хүрээнд цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт шинээр батлагдсан “Цагдаагийн албаны тухай” хуулийн дагуу өөрчлөгдөж, одоо хэлэлцүүлгийн шатанд явагдаж байгаа “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл болон бусад холбоотой хуулиуд гарахыг хүлээсэн шилжилтийн үед бид хамаарч байна.

Цагдаагийн алба хаагчид учирч болох эрсдлийг дан ганц бие махбодийн гэж тооцох боломжгүй бөгөөд сэтгэл зүйн, нийгмийн, тэр тусмаа гэр бүлийн хүрээнд учирч болох эрсдлийг тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

“Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төсөл хэлэлцэгдэж байгаа хэдий ч алба хаагчдын дунд өөрийн эрх, үүргийг ухамсарлах, тэр тусмаа учирч болзошгүй эрсдлийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, зөвхөн өөрийгөө төдийгүй хамтрагчаа хамгаалж үлдэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авагдаагүй байна.

Энэ арга хэмжээ нь ихэнхи тохиолдолд мэдээлэл, сургалтын чиг хандлагатай байх нь тодорхой. Гэтэл эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, өнөөгийн нөхцөлд нүцгэн гараараа гэмт хэрэгтэй тэмцэж, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа, иргэд олон нийтийн зүгээс цагдаагийн албанд хандах үнэлэмж буурсан, хууль ёсны шаардлагыг “эсэргүүцэх өнцөг”-өөс харж хүлээж авдаг болсон энэ үед цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлыг хэрхэн хангах асуудал хурцаар гарч ирж байна.

Энэхүү илтгэлийг боловсруулахдаа Замын цагдаагийн албаны бие бүрэлдэхүүнд тулгарч байгаа, тэр тусмаа аюулгүй байдал, эрсдлээс хамгаалах боломж, арга хэмжээг тодорхойлохыг зорьсон болно.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах

Цагдаагийн алба хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа янз бүрийн ааш араншинтай, тэр тусмаа тогтоосон дэг журмыг зөрчих хандлага бүхий иргэдтэй харьцах шаардлага гардаг. Тэр тусмаа өнөөгийн нөхцөлд иргэдийн цагдаад итгэх итгэл суларсан, хардлага сэрдлэг, буруутгасан өнгө аястай харьцаатай байх нь дийлэнхи тохиолдлыг бүрдүүлж байна.

Энэ нь цагдаагийн алба хаагчийн албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд шууд нөлөөлөхөөс гадна алба хаагчийн үүрэг гүйцэтгэх орчин нөхцөл, сэтгэл зүйн бэлтгэл, нийгмийн асуудал гэх зэрэг олон зүйлтэй шууд хамааралтай.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангана гэдэг ойлголтод бие махбод, эрүүл мэндийн аюулгүй байдал мэдээж нэн түрүүнд тавигдах нь тодорхой ч сэтгэл зүйн, материаллаг байдлын, гэр бүлийн гэх зэрэг олон хүрээнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд гарч ирэх нь тодорхой.

Сэтгэл зүйн аюулгүй байдалд хуримтлагдсан ядаргаа, албаны үйл ажиллагаатай холбоотой удирдах албан тушаалтнаас болон хамт ажиллагсдаас ирэх дарамт шахалт зэрэг нь алба хаагчийг хэвийн үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийн аюулгүй байдлаас ч багагүй үүрэгтэй байдаг.

Мөн түүнчлэн материаллаг сонирхол, хэрэг зөрчилд холбогдогчдын зүгээс үзүүлж байгаа өдөөн хатгалга, асуудлыг амар хялбараар шийдэх гэсэн сонирхол, түүний дотор “хууль сахиулах байгууллагад өөрийн хүнтэй болох” гэсэн оролдлого зэрэг нь алба хаагчийн сэтгэлзүйд юу юунаас илүү нөлөөлж, эрсдэлтэй алхам хийхэд хүргэдэг.

Үүнээс харахад цагдаагийн алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг хангахад дараах хэлбэртэй болох нь харагдаж байна.

1. Бие махбодийн аюулгүй байдал.
2. Сэтгэлзүйн аюулгүй байдал
3. Албаны ёс зүйн аюулгүй байдал

Эдгээр хэлбэрүүд нь алба хаагчийн гэр бүлийн байдал, материаллаг сонирхол, албаны бэлтгэл, тэр бүү хэл зан чанар удамшлаас хамааралтай хүчин зүйлийн нөлөөнд оршино.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь дараах хүчин зүйлийн нөлөөллөөс хамаарч харилцан адилгүй байх боломжтой. Үүнд:

- Алба хаагчийн гүйцэтгэж буй ажил үүргийн онцлог
- Биеийн болон сэтгэл зүйн бэлтгэлийн түвшин
- Алба хаагчдын дунд эрсдлээс хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний түвшин
- Материал техникийн болон удирдлагын шинжтэй арга хэмжээ
- Гүйцэтгэж буй ажил үүргийн онцлог, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан оновчтой шийдвэр гаргах чадвар
- Мэргэжлийн ерөнхий бэлтгэлийн түвшин
- Гэр бүлийн, хувийн эд материалын, ашиг сонирхлын шинжтэй нөхцөл байдал.
- Алба хаагчийн хуримтлуулсан дадлага туршлага, зан чанар, удамшлын шинжтэй хандлага

Алба хаагч хувийн аюулгүй байдлаа хангахад түүний ажилласан дадлага туршлага, албаны бэлтгэл, төрийн албанд ажиллах чин эрмэлзэл, зорилго, өөрийн үнэлэмж, үнэт зүйлсийн ойлголт, мөн түүнчлэн удирдах болон даган дуурайх этгээдээс авсан албадагын болон урамшууллын шинжтэй арга хэмжээ зэрэг нь мөн адил нөлөөлдөг.

Энэ бүх харилцааг одоо хэлэлцэж байгаа “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай” хуульд оруулсан ба “цагдаагийн албаны тухай” хууль, урьд мөрдөгдөж байсан “Цагдаагийн байгууллагын тухай” хууль зэрэгт заагдсан эрх үүрэгт байсан ерөнхий заалтаас илүү алба хаагчийн улстөрийн, нийгмийн, эдийн засгийн зэрэг баталгаа зэргийг тусад нь тодорхойлж, албан үүргээ гүйцэтгэх нөхцлийг илүү бүрдүүлэх боломжтойгоороо ялгаатай байна.

Замын цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангахтай холбоотой тулгамдсан асуудал

Өнөөдрийн байдлаар нийслэлд Монгол Улсын хүн амын хагасаас илүү хувь нь оршин сууж, улсын хэмжээний томоохон их дээд сургуулиуд, худалдаа, үйлчилгээний төвүүд хотын төв хэсэгт төвлөрсөн байдаг.

2013 оны байдлаар бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн 63 орчим хувь нь буюу 385958 нь нийслэлд бүртгэлтэй. Үүнтэй хамааралтайгаар зам тээврийн осол хэргийн дуудлагын 96,3%, бүртгэгдсэн зам тээврийн ослын 82,3%, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргийн 56,5% нь тус тус Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Дээрх тоон мэдээ Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нөхцөл байдал, хүн амын болон тээврийн хэрэгслийн төвлөрөл нягтрал ямар байгааг илтгэн харуулж байна.

Нийслэлийн Замын цагдаагийн газрын бүрэлдэхүүнд “бага бүрэлдэхүүн” 48 орчим хувь буюу 224 алба хаагч 2 хэлтэс, 8 тасагт хуваагдан замын хөдөлгөөний хяналт шалгалт, хөдөлгөөн зохицуулах чиг үүргийг үндсэнд нь гүйцэтгэдэг.

Албан үүргээ гүйцэтгэхэд замын цагдаагийн алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах нөхцөл байдлыг тооцож үзэх шаардлагатай юм. Үүнд:

1.Орчин нөхцлөөс шалтгаалсан хүчин зүйлс.

Албан үүргээ гүйцэтгэхэд замын зорчих хэсэг дээр ажиллах шаардлага гардаг: Тээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөн дунд ажил үүрэг гүйцэтгэж байгаа нь автомашинд дайрагдах, мөргөгдөж шүргэгдэх эрсдлийг байнга дагуулдаг. Албан үүргийн хүрээнд замын цагдаагийн алба хаагч нь бүх хөдөлгөөнд оролцогчдын анхааралд байх, энэ үүднээсээ зорчих хэсэг, замын хөдөлгөөний яг дунд нь ажиллах зайлшгүй шаардлагатай болдог.

Алба хаагчдад зорчих хэсэг дээр ажиллах аюулгүй ажиллагааны тогтсон дүрэм журам байхгүй, энэ талаар анхаарал болгоомжтой ажиллах талаар үүрэг чиглэл өгч, баталгаа авдаг ч энэ нь цагдаагийн албан хаагчийг хамгаалах хэрэгсэл болж чадахгүй байна.

Бусад хөдөлгөөнд оролцогчдын анхаарлыг өндөржүүлэх зорилгоор хантааз, дохиур, шүгэл зэрэг хэрэгсэл байх боловч энэ нь тэр болгон үүргээ гүйцэтгэж чадахгүйг, ялангуяа шөнө

оройн цагт зорчих хэсэг дээр гэрэлтүүлэгтэй, гэрэлтүүлэггүй янз бүрийн нөхцөлд албан үүрэг гүйцэтгэхэд хүндрэл учруулж байна.

Цагдаагийн албаны хувьд албаны дүрэмт хувцас шаардлагатай, тэр нь эдэлгээ даах, бөх хийцтэй гэх зэрэг шаардлага тавих боломжтой бол Замын цагдаагийн албанд ажиллаж байгаа алба хаагчдын хувд энэ нь “хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл”-тэй адилтган үзэх шаардлагатай юм.

Мөн түүнчлэн шинээр замын цагдаагийн албанд орж байгаа алба хаагчид зорчих хэсэг дээр хөдөлгөөн зохицуулалт, хяналт шалгалт хийх, тээврийн хэрэгслийг зогсоож шалгахдаа хэрхэн өөрийн болон хамтрагчийнхаа аюулгүй байдлыг хангах талаар тодорхой мэдлэг авахгүй, энэ талаар хуучин цагдаа нарын туршлагаас суралцах хэлбэрээр мэдлэг олж авч байгаа нь өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна.

Байнга асфальтан хучилттай зам дээр гадна агаарын халуун, хүйтэн нөхцөлд өвөлдөө асфальтан зам дээр агаарын хэм -10-аар илүү, зундаа мөн адил дунджаар 10 хэмээр илүү байдаг гэсэн тооцоо байдаг. Энэ нь замын цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндийн байдал хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйлд хамаарч байгаа бөгөөд үүнээс шалтгаалсан уушги, бөөр, нуруу, үе мөчний, ходоодны гаралтай өвчлөлт алба хаагчдын дунд түгээмэл байдаг.

Албаны хувцас хэрэглэл энэ нөхцөл байдалд нийцээгүй байгааг Замын цагдаагийн газрын өмнөх удирдлагууд анхаарч гутал, хантааз зэрэгт анхаарал тавьж, тусгайлан хийлгүүлж байсан тохиолдол бий.

2.Албаны болон сэтгэл зүйн бэлтгэл.

Замын цагдаагийн албаны онцлог, өөрийн болон хамтрагчийнхаа аюулгүй байдлыг хангах чиглэлийн сургалтанд хамрагдаагүй – өнөөдөр цагдаагийн алба хаагчийг бэлтгэхдээ тэр тусмаа бага бүрэлдэхүүний хувьд албаны бэлтгэл цагдаагийн нийтлэг ажиллагаанд зориулагдсан байдгаас бус замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаанд нийцүүлсэн, тэр тусмаа тээврийн хэрэгсэлд тавих хяналт шалгалт, зорчих хэсэг дээр хувийн аюулгүй байдлаа хангах чиглэлийн сургалт зөвхөн дурьдагдах төдий өнгөрч, албаны бэлтгэлийн байдлыг хангаж чадахгүйгээр алба хаагчдыг шууд үүрэг гүйцэтгүүлэхээр томилж байна. \

Үүнээс шалтгаалан алба хаагчид урьд ажиллаж байсан алба хаагчдын туршлагад тулгуурласан нэртэй, өөрөө өөрийнхөө ажиллах орчин, аюулгүй байдлыг хангах чиглэлээр суралцаж байна.

Сургалтанд нэгэнт “замын цагдаагийн алба”-нд тусгайлан бэлтгээгүй учир шинээр томилогдсон алба хаагчийг сургаж дадлагажуулахад дахин 2-4 сарын хугацаа шаардлагатай болдог гэсэн тооцоо байдаг.

Харилцаа, сэтгэл зүйн бэлтгэл-д хамаарах асуудлууд туйлын хангалтгүй, энэ нь дан ганц шинээр бэлтгэгдсэн алба хаагчдад биш, ажиллаж байгаа алба хаагчдын дунд зохиогдож байгаа арга хэмжээ ч танхимын сургалтаар голдуу, үлдэц, ойлголт муутай байгаа нь ажиглагдаж байна.

Замын цагдаагийн албанд орон тооны сэтгэлзүйч ажиллаж байх үед энэ төрлийн үйл ажиллагаа тодорхой эхлэл тавьж, үйл ажиллагаа нь жигдэрч байсан боловч бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр байхгүй болгосон нь нэг алхам ухарсан явдал болсон гэж үзэж байна.

Сэтгэл зүйчийн бүхэл бүтэн баг ажиллаж алба хаагчдын дунд арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Шинээр ирж байгаа алба хаагчдын Замын цагдаагийн албаны тухай “амьжиргааны” гэж боддог буруу төсөөлөл – Материаллаг сонирхолтой, цагдаагийн албанд шинээр орсон, шилжин томилогдож байгаа алба хаагчдын дунд түгээмэл тохиолддог энэ зүйл нь алба хаагчийн албаа хэвийн гүйцэтгэхэд саад учруулдаг ба ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой асуудлууд байнга гардаг.

3.Материал техникийн хангамж.

Албаны дүрэмт хувцас – өнөөдөр хэрэглэгдэж байгаа албаны дүрэмт хувцас, хамгаалах хэрэгсэл нь хөдөлгөөн зохицуулах, зорчих хэсэг дээр ажиллах шаардлага хангахгүй, хөдөлгөөнд оролцогчдод мэдээлэл өгөх, анхааруулах үндсэн үүргийг гүйцэтгэж чадахгүй байгаа болохыг алба хаагчдын дунд явуулсан санал асуулгаар тодорхой болж байна.

Нэн ялангуяа сүүлд тавигдсан шинэ дүрэмт хувцасны талаар цагдаагийн алба хаагчид нилээн гомдол тавьж байгаа бөгөөд шинэ дүрэмт хувцаснаас харшил өгч байгаа, угаахад өнгөө

алдаж гандаж байгаа, сэмэрч байгаа, шинэ хангалтын гутал хажуу хэсгээрээ чийг татаж байгаа тухай гомдол тасрахгүй байна.

Хувцасны чанарын асуудлыг хойш тавьж, гол асуудалд хандуулахад шинэ дүрэмт хувцасны хувьд замын хөдөлдгөөнд оролцогчдын анхаарлыг өндөржүүлэх, хаанаас ч тод харагдах боломж буурч, зам зорчих хэсэг дээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа замын цагдаагийн алба хаагчийг тодорхой эрсдэлд оруулж байна.

Дүгнэлт

Өнөөдрийн байдлаар алба хаагчдын хувийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа дан ганц бие махбод, эрүүл мэндийн асуудалд чиглэгдэж, албаны ёс зүй, сэтгэл зүйн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд үндсэндээ орхигдсон гэж үзэхэд буруудахгүй нөхцөл байдалтай байна.

Хууль зүйн салбарын шинэчлэлтийн хүрээнд цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдалд чиглэсэн үйл ажиллагаа тэргүүлэх чиглэлийн хэмжээнд очсон боловч аюулгүй байдлыг хангана гэсэн ойлголт нь “хадны мангаа” мэт сэтгэгдэл төрүүлэхээр, буруу зүйл хийсэн алба хаагчийг шалгаж шийтгэх зорилготой мэт харагдаж байгаа нь харамсалтай.

Алба хаагчдын хувийн аюулгүй байдалд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, энэ талаар сургаж дадлагажуулах, давтан сургалт явуулах чиг үүргийг дан ганц мэргэжлийн боловсролын байгууллага болон Хууль сахиулахын их сургуульд тохож, сургалт мэдээллийн үйл ажиллагаа хуучирсан арга хэлбэрээр явагдаж байна.

Аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай материал, техникийн хангамж хэдий сайжирч байгаа ч хэрэглээ, шинэ техник технологи эзэмших байдал энэ хурдыг гүйцэхгүй байна. Алба хаагчдад шинээр хэрэглэгдэж байгаа техник, хэрэгслийн талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах үйл ажиллагаа хоцорч байгаагаас эзэмшиж байгаа техникээ бүрэн гүйцэд ашиглахгүй, өөрийн аюулгүй байдлыг хангах талаар ашиглахгүй байгаа нь ач холбогдлыг нь бууруулж, зарим тохиолдолд огт ашиглалтгүй байлгах нь харагдаж байна.

Дэвшүүлэх санал

Цагдаагийн алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг хангахад дан ганц эрх зүйн орчин бүрдсэнээр шийдэгдэхгүй болоход анхаарал хандуулж, сургалт мэдээллийн чанарыг сайжруулах шаардлагатай. Үүнд:

1.Цагдаагийн анхан шатны сургалтад хамрагдаж байгаа алба хаагчдыг бэлтгэхдээ төрөл мэргэжлийн албадаас хүн хүчний хуваарилалтыг нарийн авч, захиалгын дагуу бэлтгэх, тухайн захиалга өгсөн албадын онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулах. Үүнд хувийн аюулгүй байдлын тухай ойлголтыг тодорхой өгч, арга хэрэгслийг нарийвчлан зааж өгөх.

Сургалтанд орчин үеийн техник технологи, харьцуулалтын болон туршилтын арга хэмжээг түлхүү ашиглаж, хэвшүүлэх.

2.Ажиллаж байгаа алба хаагчдын мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулах арга хэмжээг дан ганц ХСИС-д биш, төрөл мэргэжлийн албад тус бүрд, мөн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага тус бүрд авч хэрэгжүүлэх, үүний тулд тодорхой алба хэсгийг байгуулан, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, үүнд сэтгэл зүйч мэргэжилтнүүдийг түлхүү ашиглах.

3.Алба хаагчдын хувцас хэрэглэлийг эрүүл, аюулгүй нөхцөл шаардлагад нийцүүлсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, ямар нэг сөрөг нөлөө байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж тогтоох, арилгах.

4.Алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг хангах, үүрэг гүйцэтгэх хэвийн нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр ЦЕГ, мэргэжлийн бусад байгууллагын хамтарсан судалгааны баг гаргаж, өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийг цаашдын шийдвэр гаргахад ашиглах гэсэн саналуудыг дэвшүүлж байна.